



- Улсын хэмжээнд бүртгэгдсэн гэмт хэрэг, захиргааны зөрчлийн статистик мэдээгээр галт зэвсгээр үйлдэгдсэн гэмт хэрэг 2008 онд 71, 2009 онд 49, 2010 онд 27, 2011 онд 39, 2012 оны байдлаар 41 гарсан

<sup>4</sup> НЦГ-ын Хэв журмын хэлтсийн тайлан судалгаа.УБ.,2010

Хуулиар хүлээсэн үндсэн үүргээ манай улсын иргэн бүр шударгаар сахин биелүүлэхэд “хариуцлага” гэдэг зүйл чухал роль гүйцэтгэнэ. Өөрөөр хэлбэл Монгол Улсын Үндсэн хууль, түүнд нийцэн гарч буй бусад хуульд галт зэвсэг ашиглах, эзэмших, өмчлөх талаар нарийн зохицуулж, тэрхүү заалтыг биелүүлээгүй, бусдын нэр төр, эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгээгүй, галт зэвсэг барин айлган сүрдүүлсэн, гэмт хэрэг үйлдвэл нийгэм нь өөрийнхөө гишүүнд хууль тогтоомжийн дагуу албадлага хэрэглэж, хариуцлага хүлээлгэх зүй ёсны шаардлага урган гарна.

Сүүлийн үед буу, сумтай холбоотой хэрэг зөрчил их гарах болсон. Хамгийн гол нь сэтгэл түгшээсэн аймшигт үр дагаврыг араасаа дагуулж байгаа нь хуульчдын анхаарлыг татаж байгаа юм.

Харин нөгөө талаас нь үзвэл Монгол Улс хүний эрх, эрх чөлөө, шударга ёсыг ...эрхэмлэн дээдэлж, эх орондоо хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгэм цогцлуулан хөгжүүлэхийг эрхэм зорилго болгоно<sup>5</sup> гэж Үндсэн хуулиндаа зарлан тунхагласан билээ. Гучин наймдугаар зүйлд Засгийн газар нь “*ᠳᠥᠵᠡᠳᠡ ᠶᠳᠡ, ᠶᠳᠡ -ᠶᠡᠭᠡᠨ ᠳᠠᠶᠠᠭᠠᠭᠠᠨ ᠲᠤᠶᠠ ᠶᠡᠳᠡᠨ ᠠᠵᠤᠳᠤᠵᠡᠳᠤ, ᠠᠵᠤᠳᠤ ᠲᠤᠳᠤᠶᠠᠳᠤᠶᠡ ᠲᠤᠶᠤᠳᠤ ᠠᠳᠠᠠ ᠲᠤᠶᠠᠶᠤᠶᠤ ᠠᠠᠶᠡ ᠲᠤᠳᠤᠶᠠᠵᠡᠳᠡᠨ*” гэж заасан байдаг

Ийнхүү иргэн эрхээ эдэлж, үүргээ хүлээх нь зүй ёсны байдаг. Тиймээс ч галт зэвсгийн тооллогыг хуулинд заасны дагуу жил бүр үзлэгт оруулж шинэчилэн бүртгүүлэх шаардлагатай. Хуулийн дагуу галт зэвсгийг ашиглахын хажуугаар хууль бусаар худалдаж байгаа иргэд ч олон бий. Хууль бусаар гаднаас оруулж байгаа галт зэвсгийг олноор нь биш ганц хоёроор нь юманд хийж нууцаар оруулж ирдэг сураг ч байдаг.

Сүүлийн үед ийм тохиолдол олон гарч байна. Үүнтэй холбоотойгоор цагдаагийн байгууллагаас олон арга хэмжээг жил бүр зохион байгуулдаг. Энэ хүрээнд өнгөрсөн онд бүртгүүлээгүй татвар төлөгдөөгүй 612 галт зэвсгийг хураан авсан байна. Тухайн хүний өмч учраас зарж борлуулах нь чөлөөтэй боловч зарсан тохиолдолд тухайн хүний нэр дээр шилжүүлж цагдаагийн газарт дахин бүртгүүлэх ёстой.

Түүнчлэн бууг зарсан этгээд хэнд ямар учир шалтгаантайгаар буугаа зарж байгаагаа судлах ёстой талаар эрх зүйн зохицуулалт ч хийхэд гэмгүй юм. Ер нь тухайн галт зэвсэг эзэмшигч шилжиж суурьшсан ч галт зэвсгээ хамт шилжүүлж цагдаагийн газар бүртгүүлэх ёстой. Энэ бол иргэн хүний үүрэг.

Өнөөдөр дэлхий дахинд хүний эрхийн асуудал хурцаар яригдаж байгаа бөгөөд тэр чинээгээр түүнийг хөндөх, албадлага хэрэглэх болон галт зэвсэг ашиглах, эзэмших, өмчлөх эрхийн зөвшөөрөл олгох, хяналт тавих ажиллагаанд хүний эрхийг хангах, нөгөө талд нийгмийн аюулгүй байдлын төлөө өнөөгийн тулгамдаж буй асуудал болж байна.

**Галт зэвсэг ашиглах, эзэмших эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох арга зам**

Галт зэвсэг ашиглах, эзэмших, өмчлөх эрхийн тухай болон түүнд цагдаагийн байгууллагаас зөвшөөрөл олгох, хяналт тавих талаар хуульд тогтоомжинд хэрхэн тусгагдаж, практикт ямар аргаар хэн яаж хэрэгжүүлж, хэрэгжиж буйг өнгөрсөн одоо, цаашдын хандлагын харьцаанд шинжлэх ухаанлагаар судалснаар цаашид боловсронгуй болгох арга замыг тодруулах боломжтой юм.

Энэхүү магистрын ажлаар дээрхи асуудлын даагддаг ага оёуа агуаюуагагэ өагагеуагагэ ааеуу. Манай улс зах зээлийн харилцаанд шилжиж, эрх зүйн бүх салбарт шинэтгэл хийж, захиргааны үдд гэгэ, тэр дундаа цагдаагийн эрх зүйн гагтэй хууль, хууль тогтоомж сүүлийн жилдгугаа батлагдан аадг, үдгегөгүгэ д'аагэа буй өнөөгийн нөхцөлд цагдаагийн байгууллагаас зөвшөөрөл олгох ажиллагааны ойлоголт, түүний эрх зүйн зохицуулалтыг зөв оновчтой тайлбарлаж, хэрэглэх нь нөгөө талд иргэний эрх хамгаалах, хүндэтгэх чухал ач холбогдолтой аагааа билээ .

Гэвч цагдаагийн байгууллагаас зөвшөөрөл олгох, түүнд хяналт тавих ажиллагаа болон түүний эрх зүйн зохицуулалт нь амьдрал, практикт хэрхэн хэрэгжиж буй зэргийг судлан үзсэний үндсэн дээр цагдаагийн байгууллагын үйл ажиллагаа, түүний үр нөлөөг нь дээшлүүлэх түүнийг зөв тодорхойлох, боловсронгуй болгох арга замыг дээшлүүлэх, хэрэгжүүлэхийн ач холбогдолыг гаргаж ирэх нь чухал асуудал болж байна.

Галт зэвсэг ашиглах, эзэмших, өмчлөх эрх, цагдаагийн байгууллагаас олгож буй зөвшөөрөл, хяналт тавих ажиллагааны талаар өгүүлж, энэхүү үзэгдлийн хууль тогтоомж, түүний хэрэгжилт, цаашдын хандлагыг тодорхойлохыг магистрант би оролдлоо.

Ийнхүү дээрхи ажиллагааг боловсронгуй болгохын тулд дараахь сэдвийн хүрээнд боловсронгуй болгохоор арга замыг тодорхойлж авч үзлээ.

1. Эрх зүйн зохицуулалтын хүрээнд боловсронгуй болгох асуудлыг тодорхойлох
2. Практик үйл ажиллагааг боловсронгуй болгох хүрээнд асуудлыг тодорхойллоо.

<sup>5</sup> Монгол Улсын Үндсэн хууль. УБ 1992. 3 дахь тал

Бидний үзэж байгаагаар галт зэвсэг эзэмших, ашиглах, өмчлөхтэй холбоотой эрх зүйн хэм хэмжээг шинэчлэх, боловсронгуй болгох ажлыг дараах байдлаар хэрэгжүүлбэл зүйтэй болов уу гэж үзэж байна.

- Эрх зүйн зохицуулалтын хүрээнд зөвшөөрөл олгох, хяналт тавих ажиллагааг хууль, хууль тогтоомж, заавар дүрмийн уламжлалтай, шинжлэх ухааны түвшинд хүрсэн, тийм төрөл зүйлийн тухай хууль тогтоомжийг нарийвчлан боловсруулж сайжруулах.
- Хууль, эсхүл хуулийн дэд актуудад зарим нэг санаа нь тусгагдсан, хоорондоо авцалдаа муутай хэсэг бусад хэм хэмжээг төрөлжүүлэн нэгтгэж, нөхөн боловсруулах зэргээр дээрхи ажиллагааны төрлөөр хууль тогтоомжинд нарийвчлан зааж өгөх, эсхүл төлөөлөн тогтоосон хуульчилсан акт гаргах.
- Галт зэвсгийн тухай хууль болон бусад хууль эрх зүйн актыг шинээр боловсруулж хуульчлах, холбогдох дэд актыг сайжруулах арга замыг боловсронгуй болгох шаардлагатай байна. Энэ өөрийн практик, бусдын жишиг харгалзан боловсруулах асуудал, ялангуяа өмнө дурдсан зохион байгуулалтын шинжтэй ажил хэргийг яаж хүлээн авч боловсруулж биелүүлж, дүгнэх ажиллагааг журамлахад хамаарна гэхчилэн томъёолж болох юм.

Манай улсын цагдаагийн байгууллагаас “Галт зэвсгийг бүртгэх, гэрчилгээ олгох журам” гарсан нь үйл ажиллагаанд тус дөхөм болж байгаа ч бас л хангалттай биш байна.

Практик үйл ажиллагааг боловсронгуй болгох хүрээнд асуудалыг тодруулж түүнд тохирсон гаргалгаа хийх нь зүйтэй болов уу.

Цагдаагийн байгууллагын тоон мэдээнээс харахад улсын хэмжээнд цагдаагийн байгууллагад бүртгүүлж гэрчилгээ авсан 44764 галт зэвсэг бүртгэлтэйгээс 39953 ширхэг буюу 89,2 хувь нь тооллогод хамрагдсан ба үүнээс Нийслэлийн хэмжээнд 11334 галт зэвсэг бүртгэлтэйгээс 9762 ширхэг буюу 86,1 хувь нь арга хэмжээний хүрээнд тооллогод хамрагдсан байна<sup>6</sup>. Энэ чиглэлээр

Цагдаагийн байгууллагаас галт зэвсэг эзэмших, ашиглах, өмчлөх эрхийн зөвшөөрөл олгох ажиллагааны эрх зүйн зохицуулалт, практик дээр хийгдэж байгаа үйл ажиллагаа, нөгөө талаас иргэдээс эрх ашгийн үүднээс сайтар бодож боловсруулан оновчтой хэлбэрээр шинэчлэх асуудал хамгийн чухал юм.

Мөн практик дээр одоо үйлдэгдэж байгаа бодлого, арга хэмжээг үндэслэн үнэлж, хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Агаарын цагдаагийн байгууллагаас галт зэвсэг эзэмших, ашиглах, өмчлөх эрхийн зөвшөөрөл олгох ажиллагааны эрх зүйн зохицуулалт, практик дээр хийгдэж байгаа үйл ажиллагаа, нөгөө талаас иргэдээс эрх ашгийн үүднээс сайтар бодож боловсруулан оновчтой хэлбэрээр шинэчлэх асуудал хамгийн чухал юм.

Шилжилт хөдөлгөөн ихсэж байгаатай холбогдуулан галт зэвсгийн шилжилт хөдөлгөөнийг хийлгэхгүй авч явах, шилжиж очсон газартаа бүртгүүлэхгүй байх, галт зэвсгээ цагдаагийн байгууллагад бүртгүүлэхгүйгээр бусдад дур мэдэн худалддаг зэрэг зөрчлүүд илэрч байгаа тул энэ чиглэлээр тавих хяналтыг сайжруулах.

Аж ахуй нэгж, байгууллагын харуул хамгаалалтад ихэвчлэн тэтгэврийн насны хүмүүс ажиллаж байгаа нь харуул хамгаалалтын зориулалтаар ашиглагдаж байгаа галт зэвсэг алдагдах, цаашлаад хүний амь нас, эрүүл мэндэд хохирол учруулж болзошгүй байна. Иймд гэрээт харуул хамгаалалтын тухай хуулийн зүйл, заалтуудад нийцүүлэн үйл ажиллагаа явуулах, цагдаагийн байгууллагаас тавих хяналтыг сайжруулах шаардлагатай байгааг дурдах юун.

Мөн цаашид дэлхийн бусад орнуудад ашиглаж байгаа шүүх баллистикийн шинжилгээний шинэ арга зүй, техник төхөөрөмжийг анхааралтай ажиглан судлаж дэвшилтэд ололт амжилтыг цаг алдалгүй монголд нэвтрүүлэх нь гэмт хэргийн гаралтыг багасгах, урьдчилан сэргийлэх олон талын үр дүнтэй юм. Өнөөдөр Монголд хэн дуртай нь галт зэвсэг хэрэглэж, 18 нас хүрснээр галт зэвсэг хэрэглэх тохиолдол олон гарч байна. Тиймээс адаглаад галт зэвсэг ашиглах зөвшөөрөлтэй иргэдэд зориулсан галт зэвсгийн тусгай сургалтыг зохион байгуулах хэрэгтэй байна. Цаашилбал галт зэвсэг хэрэглэх асуудалд өдрөөс өдөрт нэмэгдсээр байгаа тул татварын бодлогоор үүнд хяналт тавих саналыг мөн гаргаж байсан. Түүнчлэн иргэд зөвхөн спорт ангийн зориулалттай зэвсэг хэрэглэх бус бусад хүчний байгууллагуудад хэрэглэх буу сумыг ч хэрэглэдэг асуудал гардаг.

Гэх мэтчлэн практик дээр дээрхи асуудлууд тулгарч байгаа бөгөөд энэ талаар 2010 оны 04 дүгээр сарын 27-нд Эрүүгийн цагдаагийн газар, Нийгмийн Хэв журам хамгаалах газар, Гадаад хэргийн

<sup>6</sup> НЦГ-ын тоо баримтаас

яам, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, Тагнуулын ерөнхий газар гээд төрийн 20 гаруй байгууллагын төлөөлөл ширээний ард уулзацгаав<sup>7</sup>.

Тэд ийнхүү уулзалдсан нь едрөөс едөрт хэрэглээ нь нэмэгдэж хvн төрөлхтнийг хөнөөх хэрэгсэл болоод буй тэсэрч дэлбэрэх бодис, галт зэвсгийн эргэлтэд тавих хяналтын талаар санал бодлоо солилцсон юм. Хууль зvй дотоод хэргийн яаманд болсон уулзалтаар галт зэвсэг, сум, тэсэрч дэлбэрэх бодисын хэрэглээ, хуулийн хэрэгжилт, тvvний тээвэрлэлт, аюулгvй байдал, тагнуулын байгууллагын болон гаалийн хяналт, шалгалт, зэвсгийн лабароторийн өнөөгийн нөхцөл байдал, бусад оронд галт зэвсэг, буу, тэсрэх бодистой хамааралтай гэмт хэрэгт холбогдсон иргэдийн мэдээлэл зэрэг сэдвийн хүрээнд илтгэл тавидаж, “галт зэвсгийн тухай хууль”-ийг шинэчлэн боловсруулах шаардлагатай гэж хэлэлцсэн боловч өнөөг хүртэл дорвитой үр дүнд төдийлөн хүрээгүй л байна.

Ажиллаж буй хяналт тавих эрх бүхий албан тушаалтнуудаас авсан санал асуулгын зарим асуултанд дараах саналыг тусгасан байна хариулжээ.

Энэ бүгдээс харахад галт зэвсэг ашиглах, эзэмших, өмчлөх эрхийн зөвшөөрөл олгох ажиллагааны эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох эхний ахлам хийгдсэн ч практик дээр үйл ажиллагааг явуулах нөхцлийг бүрдүүлэх болон албан хаагч нарт энэ талаар сургалт семинар явуулж эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх шаардлага урган гарч байна.

Цагдаагийн байгууллагаас галт зэвсэг, ашиглах, өмчлөх эрхийн зөвшөөрөл олгох ажиллагааны эрх зүйн зохицуулалт, түүний онолын аfийf идэвхдээ асуудлыг гүнзгийрүүлэн судалж, түүнд дүн шинжилгээ дөөд, тогтоосон хууль тогтоомжийг цаашид боловсронгуй болгох үүднээс дараах дүгнэлтэд хүрч байна.

Манай улс зах зээлийн харилцаанд шилжиж, эрх зүйн бүх салбарт шинэтгэл хийж, захиргааны үдб зfе, тэр дундаа цагдаагийн байгууллагын болон галт зэвсгийн тухай хуулийг шинэчлэх талаар сүүлийн жилдfäýя яригдаж хуулийн зарим нэг дэд актууд батлагдан fäд÷, ð°äæēä буй өнөөгийн нөхцөлд цагдаагийн байгууллагын захиргааны үйл ажиллагааны нэг төрөл болох галт зэвсэг ашиглах, эзэмших, өмчлөх эрхийн ойлголт, түүний эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох.

Тухайлбал: Сэтгэцийн болон ямар нэгэн гаж донтой, ял шийтгэлийн хугацаа дуусаагүй байгаа хүнд галт зэвсэг эзэмшүүлж, хэрэглэхийг хориглоно гэж заасан боловч түүнийг хэрхэн хэрэгжүүлэх талаар заалтыг нарийвчлан, тодорхойлоогүй байна.

Монгол Улсын иргэний галт зэвсэг ашиглах, эзэмших, өмчлөх эрхийн ойлголт болон түүний эрх зүйн зохицуулалтыг ялгамжтай тогтоон хэрэглэх асуудал дутагдалтай байна.

Монгол Улсын Үндсэн Хуулийн үзэл баримтлалаас үзвэл иргэд галт зэвсэг эзэмших, ашиглах, өмчлөх эрхтэй байхаар зөвшөөрсөн нь галт зэвсгийг эзэмших, ашиглах өмчлөх харилцаанд хяналт тавих ажилд хүдрэл учир ч байна. (Галт зэвсгийг өмчлөх эрхийг хязгаарлах нь зохистой гэсэн хандлага шийдвэрлэж буй хэргүүдэд давамгайлж байна). Мөн Үндсэн хуулийн “Хүн эрх, эрх чөлөөгөө эдлэхдээ үндэсний аюулгүй байдал, бусад хүний эрх, эрх чөлөөг хохироож, нийгмийн хэв журмыг гажуудуулж болохгүй” гэсэн 19-р зүйлийн 3 дахь заалтаар, иргэдийн галт зэвсэг эзэмших, ашиглах, өмчлөх эрх нь бусдын эрхээр хязгаарлагдаж болох юм.

Эрүүгийн хууль болон бусад хууль тогтоомжид, хууль бусаар fäæēí çðēōēäēðōäē áóó, ñòì ðōäæäāð, ðōäæäāì ääð çēäýēä үдçäæēí ðäðēōēäāä ðçýýēäýðýð çääāāāçé, ääēð çýāñýä,ñòì ðýðýāñýē àēäēäāāā ääēäōōēäāāā ðäēäāāð fìðñāñí ðýíäēð ñōē ääēäā çýðýä íü íēñēýēēēí çäðōōāāā fìñí fäæēí çðēōēäēðōäē áóó, ñòì ēðäýäēēí ääð äýðýýñ ðōäæäāāēäāāāð ýāāāē áçðýí ðāñēāí çñññāāíðäçé ääēíä.

Иймээс галт зэвсэг ашиглах, эзэмших, өмчлөх эрхийн зөвшөөрөл олгох, хяналт тавих үйл ажиллагаа түүний эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгохын тулд дараах саналыг дэвшүүлж байна.

- Галт зэвсгийн тухай хууль тогтоомж түүнд нийцүүлэн гаргасан эрх зарим актыг шинэчлэх, зарим өөрчлөлт оруулах.
- Галт зэвсгийн тухай хууль”-ийн 5.1-т заасан “...18 насанд хүрсэн, эрх зүйн бүрэн чадамжтай...” гэж заасан байна үүний 18 насыг 21 буюу түүнээс дээш гэж нэмэлт оруулах.
- Мөн 5.2-т заасан “... архаг архичин, мансуурах донтой гэж тооцогдсон этгээд галт зэвсэг өмчлөх, эзэмших, ашиглах эрхгүй...” гэж заасан боловч түүнийг тодорхойлох талаар хуульд нарийвчлан заагаагүй байх тул эрүүл мэндийн үзлэгт хамруулж зөвшөөрөл олгох талаар зохицуулалт оруулах.
- ГЗТХ-ийн 10.4. “...Галт зэвсэг өмчлөгч иргэн энэ хуулийн 5.2-т үл хамаарах, 5.1-д заасан шаардлага хангасан этгээдэд галт зэвсгийг итгэмжлэлийн үндсэн дээр ашиглуулж болно...” гэж заасан байна энэ нь галт зэвсгийн итгэмжлэлийг бүртгүүлэх талаар зааж өгөх.

<sup>7</sup> 2010-04-28 11:10:49 , Мэдээний дугаар: #1170698

- Энэ хуулийн 13.1-д заасан хүсэлт хүлээж авсан цагдаагийн байгууллага 14 хоногийн дотор тухайн иргэний үнэмлэх, хуулийн этгээдийн гэрчилгээг хянан үзэж, энэ хуулийн 5.1-д заасан шаардлага хангасан, 5.2-т заасан харшлах шалтгаан байхгүй бол зөвшөөрөл олгоно.
- Энэ хуулийн 21 дүгээр зүйлд заасан торгох шийтгэлийн хэмжээг нэмэгдүүлэх, үр нөлөөг нь дээшлүүлэх шаардлагатай байна.
- Мөн 19 дүгээр зүйлийн “галт зэвсэг хураах” гэсэн заалтын 1.1, 2, 3, 4т 21 дүгээр заалтын захиргааны хариуцлагаас тусд нь зохицуулалт хийсэн нь зохимжгүй мэт санагдана. Гэх мэтчилэн эрх зүйн зохицуулалтын хувьд маш олон санал хэлж болохоор байна.
- Галт зэвсгийн тухай хуульд заасан ял шийтгэлтэй хүнд галт зэвсгийг эзэмшүүлж болохгүй гэсэн заалт нь бүрэн хязгаарлалт тогтоож чадахгүй байгаа учир уг хуулинд “урьд өмнө нь эрүүгийн хуулийн тусгай ангийн зүйл хэсэгт заасан гэмт хэрэг үйлдэж ял шийтгүүлж байсан хүнд галт зэвсгийг эзэмшүүлэх, ашиглуулах, өмчлүүлэхийг хориглоно” гэж өөрчлөлт оруулах.
- Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журмын 503 дугаар тушаалыг боловсронгуй болгох.  
Тухайлбал: Цаāāāāēēī āāsāōōēēāā īdāūī, dōōēēēī ūdāūūāīйн āāēō cūāñā āčdōāčĕŷdээр ирүүлсэн баримт, бичигт эмчийн эрүүл мэндийн үзлэгийн дүгнэлт, сургалтанд хамрагдсан сертификатыг үзэж олгох, мөн журамд тодорхой хугацаатай галт зэвсэг ашиглах зөвшөөрөл олгож дахин сунгуулж байхаар зааж өгөх зэрэг болно.